



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 526

Улаанбаатар хот

**Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 он, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 955.8 (Есөн зуун тавин таван сая найман зуу) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Энхтүвшин)-д дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

2.2. Өмчлөл тодорхойгүй болон тухайн байруудын өмчлөлд байгаа ус, дулаан дамжуулах төвүүдийн судалгааг нэгтгэн гаргаж, хөрөнгийг ашиглалтад хүлээн авах асуудлаар тодорхой санал боловсруулан эрх бүхий байгууллагаар дамжуулан төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх;

2.3. “Чандмань Налайх” орон нутгийн өмчит үйлдвэрийн газартай байгуулсан хамтран ажиллах гэрээний хавсралтад заасан түрээсээр ашиглаж байгаа, түрээсээр ашиглуулж байгаа хөрөнгийн нэр төрөл, үнэ, үнэлгээг нягтлан шалгах, өмч хамгаалах Байнгын зөвлөл, техникийн комиссын дүгнэлтээр баталгаажуулах;

2.4. Батлагдсан төлөвлөгөөнд гарсан өөрчлөлтийг хагас, бүтэн жилээр тодотголд тусгуулах талаар эрх бүхий этгээдэд санал хүргүүлэх, шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах;

2.5. Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, бусдын эзэмшил газар дээр байрладаг “Шинэ налайх” ус дулаан дамжуулах төвийн доорх газрыг баталгаажуулах, үнэлэх ажлыг зохион байгуулах, Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын 6, 7 дах заалтыг хэрэгжүүлэн ажиллах;

2.6. Компанид мөрдөж байгаа журам, эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийж, хүчингүй болгох, шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах;

132006257
27-r huraldaan.docx

2.7.Тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй Улсын дугааргүй, компрессорыг машин тоног төхөөрөмжийн дансанд шилжүүлэх асуудлыг эрх бүхий этгээдэд тавьж шийдвэрлүүлэх;

2.8.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмыг мөрдөн ажиллах;

2.9.Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй, 1 жил ба түүнээс дээш хугацаатай авлагыг барагдуулах, цаашид найдваргүй авлага үүсгэхгүй ажиллах;

3.Энэхүү хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг давтан гаргасан, хяналт тавих чиг үүргээ биелүүлээгүй албан тушаалтан нарт хариуцлага тооцдог байхыг “Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

4.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх.

6.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн
2023.10.27 дугаар тогтоолын хавсралт



“НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД
ХИЙСЭН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ ТҮҮНИЙГ
АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн (сая.төг)	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Батлагдсан төлөвлөгөөнөөс зардлыг хэтрүүлсэн. 2021-2022 оны зорилтот түвшингийн төлөвлөгөөнд тодотгол оруулаагүй.	378.3	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 76.1.9, Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний заалтыг мөрдөн ажиллах.
2	Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг зөрчсөн.	577.5	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмуудын хэрэгжилтийг ханган ажиллах.
3	Хууль эрхзүйн өөрчлөлтийг компанийн үйл ажиллагааны оцлогт нийцүүлэн боловсруулах, хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй.	-	Компанийн тухай хуулийн 76.1.18 дугаар заалт, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллах.
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын дүн		955.8	(есөн зуун тавин таван мянга найман зуун төгрөг)